4.10 Цагдаагийн хэлтсийн тохижилт, засварын ажлыг хийж гүйцэтгэж байгаа ажилчдын хүнсэнд хамтын сангийн малнаас хэрэглэж болно.

4.11 Жилд алба хаагч нарт тусламжыг нэг удаа олгоно.

4.12 Цагдаагийн хэлтсийн алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор 1,000,000 сая /нэг сая/ хүртэл төгрөгийг зарцуулж болно. /Нэмэх санал гаргасан/

4.12 Хамтын санд 3 жил дараалан мөнгөн тусламж өгсөн алба хаагч нар хамтын сангаас 3 жилд ямар нэгэн тусламж, дэмжлэг аваагүй тохиолдолд буцаан 50 хувийн мөнгийг олгоно. /хасах санал гаргасан/

**Жич**: Алба хаагч нар хамтын сангаас тусламж болон гарсан зарлагын баримтыг 14 хоногийн хугацаанд бүрдүүлж өгнө.

Уг журмын 2.3-д хадам эцэг эх нас барсан гэсэн заалтыг нэмж оруулахаар алба хаагчдын саналыг үндэслэн оруулсан.

Цагдаагийн хэлтсийн даргын 2022 оны 02
дугаар сарын 25-ны өдрийн А/11 тоот
тушаалын хавсралт

4216121851 9018999

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН АЛБА ХААГЧДЫН ХАМТЫН САНГИЙН ЖУРАМ

## Нэг: Хамтын сангийн хуримтлал үүсгэх, тайлагнах

1.1 Хамтын сангийн зарцуулалтыг сонгогдсон алба хаагчид хариуцаж улирал бүр тайланг гаргаж бие бүрэлдэхүүнд мэдээлнэ.
1.2 Алба хаагчдаас 10000, энгийн ажилчид болон олон нийтийн цагдаа нараас 5000 төгрөгийн сар бүр хурааж хамтын санг бүрдүүлнэ.

## Хоёр: Хамтын сангаас жилд нэг удаа /хассан/ дараахи тусламжийг олгож болно

2.1 Алба хаагч, энгийн ажилчид эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд жилд нэг удаа /нэмж оруулсан/ 10 хүртэл хоногт 20,000 /30,000 болгосон/ төгрөг, 10-аас дээш хоногт 50000 /60000 төгрөг болгосон/ төгрөг /сувилалд сувилуулсан тохиолдолд дээрхи заалт хамаарахгүй/
2.2 Шинээр гэр бүл болж байгаа алба хаагчид гэрлэлтийн баталгааг үндэслэн хамтын сангаас 50000 төгрөг
2.3 Алба хаагчийн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд, өвөө, эмээ, төрсөн, ах эгч, дүү, **хадам эцэг, эх** нас барсан тохиололд 100000 төгрөг
2.4 Гэр бүлд шинээр хүүхэд мэндэлсэн /төрсөн/ тохиолдолд 100000 төгрөгний хадгаламжын дэвтэр нээж өгөх.
2.5 Алба хаагч болон түүний эхнэр, нөхөр, төрсөн эцэг, эх, хүүхэд 1 сараас дээш хугацаагаар эмчилгээ сувилгаа, хагалгаанд орсон бол 50000 төгрөг, гадаад улсад эмчилгээ хийлгэх бол 100000 төгрөг.
2.6 Цагдаагийн хэлтсийн алба хаагч болон түүний ар гэр байгалийн гамшигт нэрвэгдсэн, орон гэргүй болсон, гал түймэрт өртсөн тохиолдолд 500000 төгрөгийн тусламж үзүүлж, хамт олон өөрсдийн санаачилгаар мөнгөн хөрөнгө бүрдүүлж, хандив өгч болно.

## Гурав: Хамт сангаас дараахи тохиолдолд зарцуулна

3.1 ЦЕГ-ын харьяа алба, орон нутагт албан тушаал дэвшсэн алба хаагч нарт 100000 төгрөг хүртэл бэлэг дурсгалын зүйл гардуулах

3.2 Тэтгэвэрт гарч байгаа алба хаагч нарт 100000 төгрөг хүртэл бэлэг дурсгалын зүйл гардуулах
3.3 Аймаг орон нутгийн /Аймгийн аварга шалгаруулах/ болон бүсийн уралдаан тэмцээн, сургалт, спорт, соён гэгээрүүлэх ажилд тус бүрт 50000 төгрөг /эрэгтэй, эмэгтэй багуудын мандат, бооцооны мөнгийг олгох/
3.4 ЦЕГ-аас зохион байгуулж байгаа шалгалт болон ЦЕГ-ын зөвлөлийн гишүүд орон нутагт ажиллах үед 100000 төгрөг хүртэл бэлэг дурсгалын зүйл
3.5 Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд амжилт үзүүлж байгууллагын нэр хүндийг өндөрт гаргасан алба хаагч нарт 100000 төгрөг хүртэл бэлэг дурсгалын зүйл гардуулах
3.6. Аймагт болон цагдаагийн хэлтэст зохион байгуулагдах уралдаан тэмцээнд 30000 төгрөг хүртэл /50,000 төгрөг/
3.7 Шинэ жил, Эх үрсийн баяр, цагдаагийн баяр зэрэг тэмдэглэлт өдрүүдэд хамт олны хурлаар хэлэлцэн хамтын сангийн мөнгөнөөс тус тус зарцуулна.
3.8 Цагдаагийн хэлтсийн алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор 1,000,000 сая /нэг сая/ хүртэл төгрөгийг зарцуулж болно. /Хасах санал гаргасан/

## Дөрөв: Хамтын сангийн мөнгөн хуримтлалыг өсгөх зорилгоор

4.1 Нэг алба хаагчид 300000 хүртэл төгрөгийг сарын 0,5 хувийн хүүтэйгээр 3 сар хүртэл хугацаагаар зээлүүлж болно. Зээлдүүлэх мөнгөний хэмжээ нь 300000 төгрөгнөөс хэтрэхгүй байна. Зээлийг хугацаанд төлөөгүй тохиолдолд хоног тутам 1000 /нэг мянган/ төгрөгний хүү төлнө. /хасах санал гаргасан/
4.2 Зээлийг хугацаандаа төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн алба хаагчдад 1 жилийн хугацаанд дахин зээл олгохгүй. /хасах санал гаргасан/
4.3 Хамтын сангийн малын ашиг шим болох ноос, ноолуураас олсон орлогыг хэлтсийн тохижилт, засварын ажил, /хассан/ малчныг урамшуулах болон өвс, тэжээл, тариалга угаалга, ээмэгжүүлэхэд гарах зардалд зарцуулж болно
4.4 Малын тоо толгойг 400-аас бууруулахгүй байна.
4.5 Хамтын сангийн малаас алба хаагчдад хөнгөлөлттэй үнээр олгож болно.
4.6 Хамтын сангийн малын өсөлтөөс шалтгаалан 4.5 дах заалтыг сангийн гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
4.7 Хамтын сангийн малыг үүлдэр угсааг сайжруулах зорилгоор ашиг шимийн орлогоос мал худалдаж авч болно.
4.8 Бүсчилсэн сургалт, тэмцээн уралдаан, нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хэв журмын хамгаалалт, байгууллагын ой, цагдаагийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд хамтын сангийн малнаас хэрэглэж болно.
4.9 Цагдаагийн төв байгууллага, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, харьяа нэгжийн төлөөлөгчид тус орон нутагт албан ажлаар ирсэн тохиолдолд хоол хүнсэнд хамт сангийн малнаас зарцуулж болно.